

байртай холбоотой татсан мөнгө байгаа. Ирэх жилээс эцсийн тооцоо гарснаар дээрх дүн нэмэгдэж, хасагдах магадлалтай. Бид ААНОАТ-ын тухай хуулийнхаа дагуу орлогоо хүлээн зөвшөөрөх ёстой. Тэр журмаараа л явж байгаа.

С.Мягмарсүрэнгээс: 4-р блок нь хэзээ дуусаж, хэдээр боруулагдах вэ?

Б.Зоригоос: 4-р блок барилга маань босоод 3 жил болчихсон, хөрөнгө оруулагч нар Ковидоос болоод ирж чадаагүй, барилгын ажил үндсэндээ 3 жил таг зогссон. Үүнтэй холбоотой хийсэн байсан хаалга, цонх, сан, цахилгаан гээд дахин хийх ажил гарч ирж байна. ийм учраас одоогийн байдлаар өртөг тооцоолох боломжгүй. Уг нь 70%-ийн гүйцэтгэлтэй байсан. Одоо дээрх шалтгаанаар 60%-ийн гүйцэтгэлтэй болж байна гэв.

Ж.Энхтунгалагаас: Элсэн чихэр ямар үнэ ханштай байна?

Б.Зоригоос: Бид татан авалт хийгээгүй байгаа. Маш өндөр үнэтэй болсон байна. түр харзнаж л байна, зах зээлийнхээ хуулиар тэгээд нэг үнэ тохироод авах л байх гэв.

Даргалагчаас: Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё.

Нарийн бичгийн даргаас: Материалимпэкс ХК-ийн дүрэмт ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 3 жил байхаар журамласан байдаг. Иймд 2020 онд сонгогдсон гишүүдийн маань бүрэн эрхийн хугацаа энэ хурлаар дуусгавар болж байна. 2023 оны 03 сарын 15-нд ХЭЭХ-ын тов зарласан ТУЗ-ийн тогтоол гарснаас хойш бид өөрийн компанийн сайт дээр болон өдөр тутмын Өдрийн сонинд 2 удаа ТУЗ-ийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалтын зарыг зохих журмын дагуу тавьсан. Үүний дагуу хараат бус гишүүнд 4 хүн материалаа ирүүлсэн бөгөөд ердийн гишүүнд 6 хүн материалаа ирүүлж нэр дэвшиж байна гээд нэр дэвшигч нэг бүрээр танилцуулав /хавсаргав/.

Нарийн бичгийн даргаас: Нэр дэвшигчид маань гадаа хүлээж байгаа. Шаардлагатай бол эрхэм хувьцаа эзэмшигч та бүхэн биечлэн асууж тодруулах зүйл байвал асууж болно гэв.

Оролцогчид: Биечлэн асуух асуултгүй гэв.

Даргалагчаас: ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчидтэй холбоотой асуух асуулт, санал байна уу?

Оролцогчид: Байхгүй гэв.

Даргалагчаас: За хэнийг сонгох нь таны эрх тул санал авах хуудас тараагдах үед асууж тодруулсан ч нээлттэй шүү. Дараагийн хэлэлцэх асуудал ТУЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны төсөв, цалин урамшууллын хэмжээг батлах асуудал байгаа.

Цалин урамшууллын хорооноос ирүүлсэн саналыг уншиж танилцуулаад асуух асуулт байна уу? /саналыг хавсаргав/

Оролцогчид: Байхгүй гэв.

Даргалагчаас: "Материал кредит" ХХК-ийн тухай асуудлыг хэлэлцүүлье.

2019 оны ХЭЭХ-аар ББСБ-ын үйл ажиллагаа эрхлэх зориулалтаар Материал кредит ХХК-ийг үүсгэн байгуулж байсан. Үүсгэн байгуулагч нь манай Материалимпэкс ХК. Гэтэл ББСБ-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах болтол 2,5 тэрбум төгрөгийн босгыг бид үйл ажиллагаагаараа нотолж заавал байршуулах шаардлагатай болсон. Гэтэл өнөөх л Ковидын нөхцөл байдал үүсч энэ аусудал хойшлогдсон. Одоо бид үйл ажиллагаа жигдэрч байгаа тул бусад үйл ажиллагаагаа идэвхжүүлэх шаардлагатай. Бидний 2019 онд баталж байсан ББСБ-тай холбоотой дүрэм, журмууд өөрчлөгдсөн тул шинэчлэх шаардлагатай байгаа юм. Энэ ондоо багтаагаад ББСБ-ын тусгай зөвшөөрлөө авах санаатай байна. Иймд энэ асуудлыг үүсгэн байгуулагчийн шийдвэрээр батлах ёстой. Журмууд л шинэчлэгдсэн батлагдах юм, өөрөөр өөрчлөлт байхгүй, дүрэм хэвээрээ, захирал хэвээрээ, үйл ажиллагааг сэргээн явуулахыг зөвшөөрч байгаа эсэхэд саналын хуудсаараа та бүхэн саналаа өгөөрэй.

Материал кредит ХХК-ийн үйл ажиллагааг сэргээх, журмуудыг шинэчлэн батлах асуудалтай холбоотой асуух асуулт, санал, хүсэлт байна уу?

Ж.Энхтунгалагаас: Хөдөлгөөнгүй байгаа компани ч байна уу юу ч байна үйл ажиллагаатай болгож идэвхжүүлж байгааг дэмжилгүй яах вэ гэв.

Бусад оролцогчид: Асуух асуултгүй гэв.

Даргалагчаас: Монгол-Имperi турc ХХК-ийн талаарх асуудлыг Б.Зориг гишүүнээс хэлэлцүүлье.

Б.Зоригоос: Монгол-Имperi турc ХХК нь 2002 онд үүсгэн байгуулагдсан, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг. Сүүлийн 10 жил мөн л идэвхтэй үйл ажиллагаа явуулаагүй. Энэ жилээс бид үйл ажиллагааг нь эхлүүлэх, заавал аялал гэсэн үйл ажиллагаагаар хязгаарлахгүйгээр орлого олж, ашигтай ажиллах омпанийн үндсэн зорилгын хүрээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулахыг зорьж байна. Батлагдсан дүрэм маань өнөөгийн үйл ажиллагаанд тохиролмжгүй холбогдох хуль, дүрэм өөрчлөгдсөн байгаа тул нийцүүлж шинэчлэн батлах төслийг оруулж байна. Мөн Монгол-Имperi турc ХХК-ийн захирлаар Д.Тунгалагийг томилуулахаар хэлэлцүүлж байна. Д.Тунгалаг нь манай томоохон хувьцаа эзэмшигч, компанийн дотоод үйл ажиллагааг хариуцаж явдаг хүн байгаа гэв.

Даргалагчаас: Хэлэлцүүлж буй асуудалтай холбоотой асуух асуулт, санал хүсэлт байна уу?

Ж.Нарантуяагаас: Аяллын үйл ажиллагаа эхэлвэл хувьцаа эзэмшигчдэд ямар нэгэн хөнгөлөлт үзүүлэх үү?

Б.Зоригоос: Манайх өмнө нь дотоод болон гадаадын аялал зохион байгуулж байсан олон жилийн туршлагатай. Бид хувьцаа эзэмшигч, байнгын үйлчлүүлэгч, компанийн ажилчиддаа тодорхой хэмжээний хөнгөлөлт, урамшууллыг үзүүлдэг байсан. Одоо харин үйл ажиллагаа эхлээгүй байхад хөнгөлөлт үзүүлэнэ үзүүлэхгүй гэдэг арай эртэдсэн асуудал байна. Аялал жигдрээд ирхээр энэ асуудал тодорхой болно гэв.

Даргалагчаас: Хэлэлцсэн асуудлуудтай холбоотой асууж, тодруулах зүйл байна уу?

Оролцогчид: Өөр асуух асуултгүй гэв.

Даргалагчаас: Хэлэлцэх асуудал дууслаа. Мэдээллийн чанартай сонсох зүйл бол бид ногдол ашгийн талаарх мэдээлэл тайлангаа тавих үүрэгтэй байдаг. Энэ жилийн тухай нэгж хувьцаанд 300 төгрөгийн ногдол ашиг тараасан байгаа. Та бүхэн бүгд мэдэж байгаа байх. Ногдол ашигтай холбоотой асуух асуулт, санл байна уу?

Оролцогчид: Асуух асуулт байхгүй гэв.

Даргалагчаас: Хэлэлцэх асуудал болон мэдээллийн чанартай сонсох асуудлууд дууслаа. Хувьцаа эзэмшигчдэд асуух асуулт байна уу? Асуулт хариултдаа орцгооё.

Оролцогчид: Асуух асуулт байхгүй гэв

Даргалагчаас: Санал хураалтдаа оръё. Тооллогын комиссоос саналыг хуудсыг тараая.

Тооллогын комиссын гишүүдээс хувьцаа эзэмшигчдэд саналын хуудас тарааж, бөглөх зааврыг танилцуулав.

Санал хураалт 12:15 цагт эхлэв.

Хурал 12:15 цагт завсарлаж, хурал 12:25 цагт үргэлжлэв.

Тооллогын комиссын дарга Н.Түмэндэмбэрэлээс: Тооллогын дүнгийн тухай комиссын тогтоол уншиж танилцуулав. Утга нь:

1. Саналын хуудаснуудаас 12ш саналын хуудсыг хүчинтэйд тооцсугай.
2. Хүчингүйд тооцогдсон саналын хуудас байхгүйг дурьдсугай.
3. Хүчинтэйд тооцогдсон саналын хуудсаар өгсөн санал хураалтыг тоолоход хэлэлцүүлж буй асуудлыг доорхи хувиар зөвшөөрснийг тогтоосугай. Үүнд :
 - 3.1 Компанийн 2022 үйл ажиллагааны болон санхүүгийн байдалд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг зөвшөөрсөн, баталсан 100 хувь

3.2 Компанийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг зөвшөөрсөн, баталсан 100 хувь

3.3 Компанийн 2023 оны бизнес төлөвлөгөөг зөвшөөрсөн, баталсан 100 хувь

3.4 Компанийн ТУЗ-ийн гишүүдийг сонгосон хувь:

3.4.1 Ердийн гишүүн Б.Зориг – 869,239.5 буюу 99,9%

3.4.2 Ердийн гишүүн Д.Оюун – 869,239.5 буюу 99,9% %

3.4.3 Ердийн гишүүн П.Баатарцэрэн – 869,239.5 буюу 99,9% %

3.4.4 Ердийн гишүүн Д.Даваа – 869,239.5 буюу 99,9% %

3.4.5 Ердийн гишүүн Ш.Ганзориг – 869,239.5 буюу 99,9% %

3.4.6 Ердийн гишүүн Д.Баатардорж – 869,239.5 буюу 99,9% %

3.4.7 Хараат бус гишүүн Ц.Ариунаа – 769,982 буюу 88,5%

3.4.8 Хараат бус гишүүн Б.Үүрийнтуяа – 100,661 буюу 11,5%

3.4.9 Хараат бус гишүүн Г.Хонгор – 867,851 буюу 99,8%

3.4.10 Хараат бус гишүүн Б.Энх-Амар – 869,247 буюу 99,9%

3.5 ТУЗ-ийн 2023 оны үйл ажиллагааны төсөв, гишүүд, нарийн бичгийн даргын цалин урамшууллын хэмжээ, баталсан 100 хувь

3.6 Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгосон хувь:

3.6.1 "Ниямазон аудит" ХХК – 100 %

3.7 "Материал кредит" ХХК-ийн үйл ажиллагааг сэргээж, журмуудыг шинэчлэн баталсан – 100%

3.8 "Монгол-Импери турс" ХХК-ийн дүрмийг шинэчлэн баталж, гүйцэтгэх захирлыг томилсон – 100% .

Даргалагчаас: Тооллогын комиссын дүнтэй холбоотой асуух асуулт байна уу?
Оролцогчдоос: Байхгүй гэв.

Даргалагчаас: Тооллогын комиссын тогтоолыг үндэслээд өнөөдрийн ХЭХ-аас дараах тогтоолууд гарч байна. Тогтоол №01 утга:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг Хавсралт №01-ээр, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг Хавсралт №02-оор, Компанийн 2023 оны бизнес төлөвлөгөөг Хавсралт №03-аар тус тус баталж,
2. Тайлант оны үйл ажиллагааны ололтоо бататган, эрхэм зорилго, зорилтоо биелүүлэхэд тодорхой бодлого чиглэл боловсруулан хэрэгжүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон компанийн удирдлагуудад даалгаад,
3. Компанийн санхүү, бизнесийн үйл ажиллагаанд хийсэн Аудитын хорооны зөвлөмж, дүгнэлтийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг компанийн Санхүү, эдийн засгийн хэлтэст үүрэг болгов.

Тогтоол №02. Утга:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн

1.1 Ердийн гишүүнээр:

1.1.1 Б.Зориг

1.1.2 Д.Оюун

1.1.3 П.Баатарцэрэн

1.1.4 Д.Даваа

1.1.5 Ш.Ганзориг

1.1.6 Д.Баатардорж нарыг,

1.2 Хараат бус гишүүнээр:



- 1.2.1 Ц.Ариунаа
- 1.2.2 Б.Энх-Амар
- 1.2.3 Г.Хонгор нарыг тус тус сонгож,

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн даргын нэг сарын цалин, урамшуулыг дараах хэмжээгээр тогтоов. Үүнд:

- 2.1 Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга – 2,500,000 төгрөг
- 2.2 Ердийн гишүүн – 600,000 төгрөг
- 2.3 Хараат бус гишүүн – 600,000 төгрөг
- 2.4 Нарийн бичгийн дарга – 800,000 төгрөг

3. Урамшуулал олгох нөхцөлийг Төлөөлөн удирдах зөвлөл болон түүний дэргэдэх хороодын үйл ажиллагааны журамд зааснаар олгон,

4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь хууль болон бусад холбогдох дүрэм, журамд заасан эрх хэмжээний хүрээнд үйл ажиллагаагаа явуулахыг үүрэг болгов.

Тогтоол №03. Утга нь:

1. Компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавьж, аудитын дүгнэлт гаргах байгууллагаар Монгол улсын "Ниямазон аудит" ХХК-ийг томилж,
2. "Ниямазон аудит" ХХК-тай гэрээ байгуулах эрхийг тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд олгоод,
3. Хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлтийг хууль, журмын дагуу Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгов.

Тогтоол №04. Утга нь:

1. "Материал кредит" ХХК-д Банк бус санхүүгийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэн явуулахыг зөвшөөрч,
2. Банк бус санхүүгийн байгууллага (цаашид "ББСБ" гэх)-ын дүрмийн санд хөрөнгө оруулсан хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг дараах байдлаар батлав.

№	Хувьцаа эзэмшигч иргэн болон хуулийн этгээдийн нэр	Гаргасан хувьцаа			Хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь
		Тоо ширхэг	Нэрлэсэн үнэ /төгрөгөөр/		
			Нэг бүрийн	Бүгд	
1.	"Материал импэкс" ХК	2,500,000	1000	2,500,000,000	100%

3. Хөрөнгө оруулалтын мөнгийг үүсгэн байгуулагч "Материалимпэкс" ХК-ийн 2022 оны татварын дараах цэвэр ашиг буюу Хуримтлагдсан ашгаас гаргаж төвлөрүүлэхийг зөвшөөрөөд,
4. "Материал кредит" ХХК нь Төлөөлөн удирдах зөвлөлгүй ажиллахаар тогтоон,
5. ББСБ-тай холбоотой дүрэм, журмуудыг Хавсралтаар баталж,
6. Компанийн гүйцэтгэх захирлаар Дагва овогтой Оюуныг томилсныг хэвээр үлдээснийг дурдав.

Тогтоол №05. Утга нь:

1. "Материал кредит" ХХК-ийн банк бус санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрөл авахад шаардагдах бичиг баримтын бүрдлийг банк болон бусад эрх бүхий байгууллагаас гаргуулан авч, Санхүүгийн зохицуулах хороонд хүлээлгэж, өгөх, буцаасан материал авах, дахин материал бүрдүүлж өгөх, гарсан зөвшөөрлийг хүлээн авах, улсын бүртгэлийн газарт бүртгүүлэх, хуулийн этгээдийн бүртгэлийн газарт нэрийн баталгаажилт хийлгэх, материал хүлээн авах, өгөх, тамга тэмдгийн баталгаажилтын код авах, тамга тэмдэг авах, дүрэм журам батлах, тушаал шийдвэр гаргах, итгэмжлэл олгох, банкинд харилцах данс нээлгэх зэрэг ББСБ-ын тусгай зөвшөөрөл эрхлэн явуулахтай холбоотой бүхий л бичиг баримтад үүсгэн байгуулагчийг бүрэн төлөөлөх эрхийг гүйцэтгэх захирал Д.Оюун /РД: ХХ73103166/-д итгэмжлэн олгож,
2. Энэхүү итгэмжлэл нь олгосон өдрөөс хойш Гурван жилийн хугацаанд хүчинтэйг.
3. "Материалимпэкс" ХК /хувьцаа эзэмшигчид/-ийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд нь Гүйцэтгэх захирал Баярын Зориг болохыг дурдав.

Тогтоол №06. Утга нь:

1. "Монгол-Импери турс" ХХК-ийн "Дүрэм"-ийг Хавсралтаар шинэчлэн баталж,
2. "Монгол-Импери турс" ХХК-ийн гүйцэтгэх захирлаар Дагвын Тунгалагийг томилон,
3. Шинэчлэн батлагдсан дүрмийг эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн өдрөөс эхлэн мөрдөж, .
4. Энэхүү тогтоол гарсантай холбоотой "Монгол-Импери турс" ХХК-ийн 2002 онд батлагдсан дүрмийг хүчингүйд тооцоод,
5. "Материалимпэкс" ХК /хувьцаа эзэмшигчид/-ийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд нь Гүйцэтгэх захирал Баярын Зориг болохыг дурдав.

Даргалагчаас: Хурлаас гарч буй тогтоолыг ХЭ-дээсээ гар өргөж давхар баталгаажуулъя. Тогтоол №01, 02, 03, 04, 05, 06-ыг батлах уу?

Бүх гишүүд: 100% гар өргөн батлав.

Даргалагчаас: Ингээд хуралдаа идэвхтэй оролцсон та бүхэнд баярлалаа. Хурал хаахаас өмнө хэлэх санал, хүсэлт байна уу?

Оролцогчид: Байхгүй гэснээр хурал 12 цаг 55 минутад дуусав.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН ТУЗ-ИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



ХУРЛЫН ДАРГА

Т.ЛХАГВАЧУЛУУН

Д.ОЮУН